

СПОРТ ЦОГЦОЛБОРЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

2004.06.30

Улаанбаатар хот

1. БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

БНМАУ, ЗСБНХУ-н Загийн газрын хооронд эдийн засаг, шинжлэх ухаан технологийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр, БНМАУ-н СНЗ-н 1986 оны 84 дүгээр тогтоолын дагуу Улаанбаатар хотын Спорт цогцолборыг ЗХУ-н техник эдийн засгийн тусламжтайгаар барихаар шийдвэрлэсэн. Усан сан бүхий төв корпус, хөнгөн атлетикийн, манеж, цэнгэлдэх хүрээлэн гэсэн 3 үндсэн хэлбэрээс бүрдэж буй энэ цогцолборын зураг төслийг 1986-1988 онд Моспроект –2 институтад Улаанбаатар хотын 3-4 хорооллын спортын цогцолбор нэртэйгээр 216 сая шилжих рублийн төсөвт өртөгтэй боловсруулжээ. Ингээд барилга угсралтын ажил 1988 онд эхлэн нийт угсралтын ажил 62 хувьтай хийгджээ. 1991-1994 онуудад нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, шилжилтийн үе, үнийн өсөлттэй холбогдуулан барилгын угсралтын явц зогсоход хүрчээ. Ингээд 1994 онд Спорт цогцолборын барилгыг дуусгахаар ашиглалтын өмнөх захиргаа анх байгуулагджээ.

Ашиглалтын өмнөх захиргаа барилга, үйлчилгээний төсөвт компаниар барилгын ажлыг гүйцэлдүүлэхээр шийдвэрлэжээ. Ашиглалтын өмнөх захиргаа Спорт цогцолборын 11.6 га талбайд байрлах, барилга байгууламжийн талбайд байгаа барилгын төмөр, бетонон хийц тоног хэрэгслүүдийг харж хамгаалах ажлыг зохион байгуулан ажиллажээ. Ингээд Спорт цогцолборын Улсын үйлдвэрийн газрын захирлаар 1999 оны 07-р сарын 05-ны өдрөөс Ү. Жигжидсүрэн томилогдон Нийслэлийн Засаг дарга, Өмчийн харилцааны газартай шинэчилсэн гэрээ байгуулан ажилласнаар бүтэц зохион байгуулалт бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан үр бүтээлтэй ажилласнаар 2000 оны 2.9 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Спорт цогцолбор Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг Төрийн өмчийн газрын 1998 оны 05-р сарын 29-ний өдрийн 29-ний өдрийн 191 дүгээр тушаалаар Нийслэлийн өмчид шилжүүлсэн. Одоогоор Спорт цогцолбор Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газрыг 2001 онд батлуулж, 2002 оны эцэст бүхэлдээ алдалгүй 11.5 мянган төгрөгийн балансын ашигтай ажиллаж цаашид ч зарим орон тоог нягтруулах замаар алдагдалгүй ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ авч иржээ. Спорт цогцолбор нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2003 оны 03-р сарын 26-ны өдрийн 39 тоот тогтоолоор татан буугдсан байна.